



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх хотын хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/156/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhburtgelaudit8@gmail.com</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---------------|--|-------------------------|----------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 61,108,249.76 | 750,346.66 |
| 1.1.2 | Дансны авлага | 440,900.00 | - |
| 1.1.3 | Татвар, НДШ - ийн авлага | 2,445,009.00 | - |
| 1.1.6 | Бараа материал | 576,409,223.30 | 358,830.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 640,403,382.06 | 1,109,176.66 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 781,072,649.77 | 14,323,888.88 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 868,725.01 | 451,737.01 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 781,941,374.78 | 14,775,625.89 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,422,344,756.84 | 15,884,802.55 |
| 2 | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,445,009.00 | 21,715,859.30 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | 28,540,824.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 658,859.00 | 21,610,750.74 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | - | 19,895,373.77 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 3,103,868.00 | 91,762,807.81 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 3,103,868.00 | 91,762,807.81 |
| 2.3 | Эзэмшигчдийн өмч | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 294,020,810.00 | 294,020,810.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 60,971,417.32 | 60,971,417.32 |
| 2.3.8 | Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 1,187,936,674.95 | 1,187,936,674.95 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -123,688,013.43 | -1,618,806,907.53 |
| 2.3.11 | Эзэмшигчдийн өмчийн дүн | 1,419,240,888.84 | -75,878,005.26 |
| 2.4 | Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн | 1,422,344,756.84 | 15,884,802.55 |

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 541,906,800.00 | 250,300,000.00 |
| 2 | Борлуулалтын өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 541,906,800.00 | 350,300,000.00 |
| 8 | Бусад орлого | 295,460,810.00 | 100,000,000.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 764,499,567.62 | 1,077,118,231.28 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 54,636,846.79 | 43,476,770.10 |
| 11 | Санхүүгийн зардал | 17,200.00 | 9,700.00 |
| 12 | Бусад зардал | 11,625,404.00 | 9,564,144.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | -715,158,059.21 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 6,588,591.59 | -1,495,026,904.59 |
| 19 | Орлогын татварын зардал | 658,859.00 | - |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 5,929,732.59 | -1,495,026,904.59 |

Налайх хотын хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|----|-----------------------------------|--------------|-------------------|
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | 5,929,732.59 | -1,495,026,904.59 |
|----|-----------------------------------|--------------|-------------------|

1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | НИЙТ ДҮН |
|--------------------------------------|----------------|-------------------------------------|---------------------------|--------------------|-------------------|
| 2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл | 294,020,810.00 | 60,971,417.32 | 1,187,936,674.95 | -123,688,013.43 | 1,419,240,888.84 |
| 2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл | 294,020,810.00 | 60,971,417.32 | 1,187,936,674.95 | -123,688,013.43 | 1,419,240,888.84 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | -91,989.51 | -91,989.51 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | -1,495,026,904.59 | -1,495,026,904.59 |
| 2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл | 294,020,810.00 | 60,971,417.32 | 1,187,936,674.95 | -1,618,806,907.53 | -75,878,005.26 |

1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 858,605,302.00 | 367,981,500.00 |
| | Татаас, санхүүжилтын орлого | 541,906,800.00 | 350,300,000.00 |
| | Бусад мөнгөн орлого | 316,698,502.00 | 17,681,500.00 |
| 1.2 | Мөнгөн зарлага (-) | 785,351,724.20 | 420,359,403.10 |
| | Ажиллагчдад төлсөн | 357,249,024.29 | 228,687,875.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 102,741,640.50 | 47,482,014.00 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 201,796,288.00 | 55,614,289.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 36,700,905.41 | 24,621,227.00 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 12,500,000.00 | 3,505,000.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 33,395,984.00 | - |
| | Бусад мөнгөн зарлага | 40,967,882.00 | 60,448,998.10 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 73,253,577.80 | -52,377,903.10 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 28,179,964.00 | 7,980,000.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 28,179,964.00 | 7,980,000.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -28,179,964.00 | -7,980,000.00 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 45,073,613.80 | -60,357,903.10 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 16,034,635.96 | 61,108,249.76 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 61,108,249.76 | 750,346.66 |

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 294,020.8 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|------------------|-----------------------------------|----------|--------------------------|------------------|------------|------------------|---------------|----------|----------|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруул аагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Санхүүгийн байдлын тайланд төрийн өмчийг хувийн өмчөөр бүртгэж, тайлагнасан | 1 | 294,020.8 | - | - | 1 | 294,020.8 | 1 | 294,020.8 | - | - | - | - |
| Дүн | 1 | 294,020.8 | - | - | 1 | 294,020.8 | 1 | 294,020.8 | - | - | - | - |

Аудитаар нийт 2,950.4 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөөгүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Худалдан авалт ибаримтаар баталгаажаагүй. | 1 | 2,950.3 | - | - | - | - | 1 | 2,950.3 | - | - | - | - |
| Дүн | 2 | 2,950.3 | | - | - | - | 2 | 2,950.3 | - | - | - | - |

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 506,293.1 мянган төгрөгийн 6 зөрчлөөс 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, нийт 506,293.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|--|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----|---------|-----------|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил | | | | | | | | | |
| | Захиалгын хүсэлт илгээж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй | 1 | 1,678.1 | - | - | - | - | 1 | 1,678.1 |
| | Дүн | 1 | 1,678.1 | - | - | - | - | 1 | 1,678.1 |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 504,615.0 | - | - | - | - | 1 | 504,615.0 |
| | Дүн | 1 | 504,615.0 | - | - | - | - | 1 | 504,615.0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | |
| | Холбогдох дээд шатны байгууллагатай онцгой нөхцөл бүхий гэрээ байгуулаагүй, Зорилтот түвшин төлөвлөгөө батлуулаагүй, орлого олоогүй. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| | Байгууллагын бүтэц орон тоо батлуулаагүй, мэргэжлийн нягтлан бодогч томилоогүй, нийт 2 орон тоотой үйл ажиллагаа явуулсан. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг ил тодоор мэдээлээгүй. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| | Ахмадын сан байгуулаагүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| | Дүн | 4 | - | - | - | 3 | - | 1 | - |
| | Нийт дүн | 6 | 506,293.1 | - | - | 3 | - | 3 | 506,293.1 |